



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/21

Улаанбаатар хот

“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн  
үйлдвэрлэл, технологийн парк”  
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн  
газрын зардлаар суралцах гэрээний  
загварыг батлах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсэг, “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын зардлаар суралцах гэрээний загварыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /А.Нямхүү/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



3150600021